



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР**

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 05

Ховд

**Г2019-2020 оны Хөдөө аж ахуйн салбарын  
өвөлжилт, хаваржилтанд бэлтгэх тухай**

Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, хадлан тэжээл бэлтгэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "Л" заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 285 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Сум, багийн Засаг дарга, Хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтэн нарт

1.1. Сумдын бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн хэмжээг хавсралтаар баталсугай.

1.2. 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах сум, багийн ажлын хэсгийг 2019 оны 08 дугаар сарын 15-ны дотор багтаан томилж, хийх ажлын төлөвлөгөөг гарган ажлын явц биелэлтэнд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг холбогдох газар, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

1.3. Хадлангийн ургацын байдал, усны түвшинг байнга хянаж тогтмол хяналт тавих

1.4. Зуншлага сайн байгаатай холбогдуулан хадлан хадах хугацааг 08 дугаар сарын 10-наас зохион байгуулах. Мөн сумдын байгаль орчны байцаагч нар хяналт тавьж, мэдээллээр хангаж ажиллах.

1.5. Хадлан, гар тэжээл, хужир шүүг хавсралтанд заасан төлөвлөгөөний дагуу бэлтгэхэд малчид, тариаланчид, мал бүхий иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж, нийт малын 30 хувийг 1 хоног тэжээхээр тооцон орон нутгийн нөөц бүрдүүлж, шаардлагатай цэгүүдэд байршуулах арга хэмжээ авах.

1.6. Хадлан тэжээл бэлтгэх техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар үйлчилгээг энэ оны 08 дугаар сарын 05-ны дотор дуусгах, хадлан тэжээл бэлтгэх багаж, тээврийн хэрэгслээр хангах ажлыг орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах.

02 00021

1.7 Өөрийн сумын нутгаас өвс бэлтгэх боломжгүй сумдад хадлангийн нөөц талбай бүхий бусад сумдын удирдлагатай хадлангийн талбайг гэрээгээр ашиглах өвс, тэжээл бэлтгүүлж худалдан авах, хужир шүүг өвс тэжээлээр солилцох зэргээр тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

1.8 Өвөл хаврын бэлчээрийн даацад тулгуурлан сум дундын болон аймаг дундын отрын бүс нутгууд, хилийн зурвас газар, байгалийн тусгай хамгаалалттай газруудад отроор өвөлжих, хаваржих өрх, малын тоо тохирон холбогдох газар, аймаг, сумдын удирдлагуудтай гэрээ хэлцлийг 10 дугаар сард багтаан зохион байгуулах.

1.9 Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчин, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах, мал эмнэлэгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангаж ажиллах.

1.10 Малчин өрх бүрийг малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлшээ бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базаах зэргээр мал өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангуулах.

1.11 Нийт хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироог бүрдүүлж, дутагталтай хээлтүүлэгчийг нөхөн тавих хуц, ухныг 12 дугаар сарын 10-ны дотор багтаан ялгаж, малчдын саналын дагуу суурь зохион байгуулж ажиллах.

1.12 Сум багийн харилцаа холбооны найдвартай ажиллагааг хангаж, цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг иргэд, малчдад тогтмол хүргэж байх.

1.13 Намрын ургац хураалтанд шаардагдах хүн хүч, техникийн бүрэн бүтэн байдал, хүрэлцээ хангамж, шатах тослох материалын нөөц бүрдүүлэхэд анхаарч, ургацыг хаягдал багатай хураан авах, хадгалах байр сав бэлтгэх.

1.14 Мал, мах бэлтгэх ажлыг эрчимжүүлэх талаар малчдад сайтар ойлгуулан тарга хүч муутай малыг бордож борлуулах, энэ ажилд мал, мах бэлтгэдэг компани, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжтэй холбоо тогтоон гэрээ байгуулах замаар газар дээр нь борлуулах ажлыг зуучлан зохион байгуулах.

2. Энэхүү албан даалгаврын заалт бүрийг сурталчилж, хэрэгжилтийг ханган, явцын мэдээг 10 хоног тутамд, биелэлтийг 10,12 дугаар сарын 15-нд тооцон гаргаж, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн, хүндэрч болзошгүй үед зам даваа хаагдах, малчдад өвс, тэжээл, эм эмчилгээний хэрэгсэл, өргөн хэрэглээний болон хүнсний бараа бүтээгдэхүүн хүргэх, цаг агаарын мэдээ мэдээллийг шуурхай дамжуулах, бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн АЗЗА, Тээвэр, авто замын газар, Эрүүл мэндийн газар, Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Хадлангийн бүс нутагт мал, малчин өрхийг 08 дугаар сарын 25-ныг хүртэл оруулахгүй байх арга хэмжээ авч, бэлчээр нутгийн зохицуулалт хийж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5.Албан даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтэнд тогтмол хяналт тавьж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд 2019 оны 10,12 дугаар сарын 20-ны дотор тус тус танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Ц.Ганданповран/, Хүнс, хөдөө аж хуйн газрын дарга /Г.Гончигсүрэн/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны  
07 дугаар сарын 25-ны өдрийн  
А/05 дугаар албан даалгаврын  
хавсралт

4.

ХАДЛАН, ТЭЖЭЭЛ, ХУЖИР ШҮҮ БЭЛТГЭХ  
НӨӨЦЛӨХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сум, дүүргийн нэр	Бэлтгэх хадлан /тн/	Бэлтгэх гар тэжээл /тн/	Бэлтгэх хужир шүү /тн/	Сумын аюулгүй нөөцөд бэлтгэх	
					Өвс/тн/	Тэжээл/тн/
1	Алтай	1500	150	414	50	30
2	Булган	22000	450	698	50	30
3	Буянт	8000	350	573	50	30
4	Дарви	800	200	499	50	30
5	Дөргөн	1200	200	329	50	30
6	Дуут	100	100	351	50	30
7	Зэрэг	3000	300	422	50	30
8	Манхан	2500	350	599	50	30
9	Мянгад	6000	350	614	50	30
10	Мөст	100	100	527	50	30
11	Мөнххайрхан	100	100	313	50	30
12	Үенч	6000	300	342	50	30
13	Ховд	5500	300	398	50	30
14	Цэцэг	100	100	384	50	30
15	Чандмань	1500	300	542	50	30
16	Эрдэнэбүрэн	2500	250	459	50	30
17	Жаргалант	700	100	291	50	30
18	Дүн	<b>61600</b>	<b>4000</b>	<b>7756</b>	<b>850</b>	<b>510</b>

-оОо